

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 7555 дугаарт бүртгэв.

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
БОЛОВСРОЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН
ТУШААЛ**

2026 оны 2 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар А/22, А/30, А/36

Улаанбаатар
хот

**АРГАЧЛАЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН НОРМАТИВ БАТЛАХ
ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг санхүүжүүлэх аргачлалыг нэгдүгээр, үйлчилгээний зардлын нормативыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аргачлал, үйлчилгээний зардлын нормативын дагуу хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлыг жил бүрийн төсөвт төлөвлөж, санхүүжүүлж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар /Б.Баярсайхан/-т даалгасугай.

3.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төлөвлөн улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхдээ энэхүү аргачлал, нормативыг жишиг болгон мөрдөхийг бүх шатны Засаг дарга, Төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

4.Аргачлалын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Боловсролын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Сангийн яамны Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт, үнэлгээний газарт тус тус даалгасугай.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД

Т.АУБАКИР

БОЛОВСРОЛЫН САЙД

П.НАРАНБАЯР

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

*Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын сайд,
Сангийн сайдын хамтарсан 2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн
А/22, А/30, А/36 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдэнд хөгжлийг дэмжих үйлчилгээг үзүүлэхэд улсын болон орон нутгийн төсвөөс шаардагдах зардлыг төлөвлөх, зарцуулахад энэ аргачлалыг баримтална.

1.2.Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасны дагуу хөгжлийг дэмжих үйлчилгээг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын, соёл, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хамтын оролцоо, дэмжлэгт тулгуурлан зохион байгуулна.

1.3.Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасны дагуу хүүхдийн хөгжлийг дэмжих, таатай орчныг бүрдүүлэх нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг бөгөөд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх сургалтын байгууллага, багш, хүүхдийн хөгжил, хамгаалал, боловсрол, соёл, спортын асуудал хариуцсан байгууллагатай хамтран ажиллана.

1.4.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг хүүхдийн ордон, зуслан, дугуйлан, хөгжлийн төв, клубээр дамжуулан зохион байгуулах бөгөөд дараах хэлбэрээр ангилж, ангилал тус бүрд зардлын нормативыг тогтооно:

1.4.1.хүүхдийн бие махбодын хөгжлийг дэмжих үйлчилгээ;

1.4.2.танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ;

1.4.3.нийгэмшихүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4, 8.2.5 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13.1.10 дахь хэсэгт заасны дагуу хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд дараах бүлгийн хүүхдийг хамруулна:

2.1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд;

2.1.2.сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэд;

2.1.3.хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд;

2.1.4.амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхэд;

2.1.5.гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч хүүхэд;

2.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд;

2.1.7.дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн хүүхэд;

2.1.8.гурав ба түүнээс дээш хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж буй өрхийн хүүхэд.

2.2.Аргачлалын 2.1-д заасан хүүхдэд чиглэсэн хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг төлөвлөн зохион байгуулахад шаардагдах зардлыг Хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлнэ.

Гурав.Удирдлага, зохион байгуулалт

3.1.Энэ аргачлалын дагуу хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллага нь төрийн болон орон нутгийн өмчит хүүхдийн ордон, зуслан, хөгжлийн төв, урлан бүтээх төв, урлаг, соёл, спортын байгууллага болон насан туршийн суралцахуйн төв байна. Эдгээр байгууллагад хүүхдийн хөгжлийн үйлчилгээний дараах зардалд санхүүжилт олгоно.

3.1.1.Багшийг гэрээгээр ажиллуулах хөлс;

3.1.2.Үйлчилгээнд шаардлагатай хэрэглэгдэхүүний зардал.

3.2.Энэ аргачлалын 3.1-д дурдсан байгууллагаар дамжуулан үзүүлэх боломжгүй хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

3.2.1.Үйлчилгээ үзүүлэх байгууллага нь “MNS 7076:2025 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”-ыг хангасан байна.

3.2.2.Үйлчилгээ үзүүлэх иргэн нь “MNS 7076:2025 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”-ын 6.4-т заасан тавих шаардлагыг хангасан байна.

3.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь хүүхдийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын хүчин чадал, нөөц, туршлагыг харгалзан үйлчилгээнд хамруулах боломжтой хүүхдийн тоон мэдээллийг гаргана.

3.3.1.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь жил бүр 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүүхдийн хөгжлийн үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах тухай зарыг цахим сүлжээ, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж, хамтран ажиллах байгууллагуудын хүсэлтийг 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хүлээн авна.

3.3.2.Хүсэлт гаргасан байгууллагуудын мэдээллийг нэгтгэн, хянаж, шаардлага хангасан байгууллагаас үзүүлэх боломжтой хүүхдийн хөгжлийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээг 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор аргачлалын 2.2 дахь хавсралтыг үндэслэж тооцоолон гаргана.

3.4.Энэ аргачлалын 2.2-т заасан бүлгийн хүүхдийг орон нутгийн

хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд эрэмбэ, жагсаалтын дарааллын дагуу хамруулах ажлыг дараах байдлаар зохион байгуулна:

3.4.1. тухайн аймаг, дүүрэгт амьдарч буй сургуулийн насны хүүхдийг аргачлалын 2.1 дэх хавсралтад заасан шалгуурын дагуу холбогдох эх сурвалж, мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн үнэлнэ.

3.4.2. хүүхэд тус бүрийн үнэлгээний нийт оноонд үндэслэн, онооны буурах дарааллаар жагсаалт үүсгэн, харгалзах онооны дагуу эрэмбэ тогтоож хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамруулна.

3.5. Сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сургуулийн нийгмийн ажилтан хүүхдийг хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулахдаа эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн таниулсан зөвшөөрлийг үндэслэнэ.

3.5.1. Хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчтэй холбоо тогтоож, аргачлалын 2.4 дэх хавсралт А-д заасан мэдээлэх хуудсын дагуу бэлтгэсэн хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах боломж, үйлчилгээг авах нөхцөл, санхүүжилтийн зохицуулалтын талаар мэдээлэл бүхий хуудсыг илгээнэ. Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн зүгээс хүүхдийг хөгжлийн үйлчилгээнд хамрагдахтай холбоотой нэмэлт мэдээ мэдээллээр хангаж ажиллана.

3.5.2. Аргачлалын 2.4 дэх хавсралтын Б-д заасан зөвшөөрлийн маягтын дагуу эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчөөс ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан болон сургуулийн нийгмийн ажилтан хүүхдийг хөгжлийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Санхүүжилтийн удирдлага

4.1. Аргачлалын 1.4-т заасан үйлчилгээнд дараах үйлчилгээний төрлийг хамааруулна.

Дд	Үйлчилгээний төрөл	Тухайн үйлчилгээний төрөлд хамаарах ангилал
1.	Хүүхдийн бие махбодын хөгжлийг дэмжих үйлчилгээ	Биеийн тамир, спортын секц, дугуйлан, сургалт (үндэсний бөх, чөлөөт, жудо бөх, хөнгөн атлетик, бадминтон, сагс, волейбол, тэшүүр, ширээний теннис, агаарын теннис, усан спорт, буудлага гэх мэт бие махбодын хөгжлийг дэмжих, чийрэгжүүлэх үйлчилгээ гэх мэт)

2.	Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ	Урлагийн дугуйлан (төгөлдөр хуур, хийл, морин хуур, эвэр бүрээ, хөөмий, хуучир, лимбэ, шанз, ятга, ёочин, дуулаач, монгол ардын ба уртын дуулаач, цирк, драм, балет, бүжгийн дугуйлан ба бусад)
		Уран бүтээлийн дугуйлан (зураг, шатар, гар урлал, зохион бүтээх, хувцас загвар, гоо зүй, соёл сүрлэн наамал, уран сийлбэр, уран баримал, уран хатгамал, уран бичлэг, арьсан урлал, уран хайчилбар, хүүхэлдэй урлал, барилгын макет дизайн ба бусад)
		ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тусгагдсанаас бусад сэдэв/ судлагдахууны хүрээнд явагдаж буй сургалт (түргэн бодолт, ой тогтоолт, сэтгэхүй, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтууд, соробан сампингийн сургалт зэрэг)
		Шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологи, сэтгэлгээний дугуйлан, сургалт (STEM)
		Эрүүл мэндийн боловсрол (эрүүл хооллолт, идэвхтэй дасгал хөдөлгөөн, бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл ахуйн дадал хэвшил зэрэг)
3.	Нийгэмшихүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ	Амьдрах ухааны сургалт (өөртөө итгэх итгэл, харилцаа, шийдвэр гаргах, тунгаан бодох, санхүүгийн боловсрол, хүчирхийллээс хамгаалах гэх мэт)
		Утга зохиолын хөтөлбөр (тэмдэглэл хөтлөх, яруу найргийн дугуйлан)
		Урлаг засал (арт терапи гэх мэт хөтөлбөрүүд)
		Боловсролын хөтөлбөрүүд
		Үндэсний өв соёл, уламжлалыг таниулах дугуйлан, сургалт

4.2.Аргачлалын 4.1-т заасан үйлчилгээний хэрэглэгдэхүүнд хүүхдийн насны онцлогт тохирсон хөгжмийн зэмсэг, сургалтын техник хэрэгсэл, сургалтын материал, ном гарын авлага, дэвтэр, үзэг харандаа, уран зураг, спортын тоглоом, хэрэгсэл зэрэг хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд шаардлагатай хэрэгсэл багтана.

4.3.Аргачлалын 4.1-д заасан хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд нэг хүүхэд жилд 3 сараас ихгүй хугацаанд хамрагдах бөгөөд холбогдох зардлыг дараах аргачлал, нормативаар тооцно.

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ=
Хамрагдсан хүүхдийн тоо * зардлын норматив * итгэлцүүр * Хамрагдах сарын тоо

Хамрагдсан хүүхдийн тоо – хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний 3 ангиллын аль нэгд хамрагдсан хүүхдийн тоо

Хамрагдсан сарын тоо – хүүхдийг хамруулах сургалтын үргэлжлэх хугацааг 3 хүртэл сарын тоогоор

4.4.Аргачлалын 2.2-т заасан бүлгийн хүүхэд хүүхдийн зусланд жилд нэг удаа хамрагдах бөгөөд зардлыг аргачлал, нормативын дагуу

тооцож олгох ба хоногийн дээд хязгаар 7-оос ихгүй байна.

ЗУСЛАНГИЙН НИЙТ ЗАРДАЛ

= Зусланд хамрагдсан хүүхдийн тоо*зардлын норматив*хоногийн тоо

4.5.Тухайн жилд нэг хүүхдэд үйлчилгээний ангилал, төрөл давхардуулан улсын төсвөөс дэмжлэг үзүүлэхгүй.

4.6.Аргачлалын 2.2-т заасан бүлгийн хүүхэд хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах зардлыг улсын төсвөөс хоёр жилд нэг удаа санхүүжүүлнэ.

4.7.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлын хэмжээнд тооцох өсөн нэмэгдүүлэх итгэлцүүрийг зуслангийн зардалд тооцохгүй.

Тав.Төлөвлөх, санхүүжүүлэх

5.1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын болон соёл, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараа оны төсвийг орон нутгийн харьяа байгууллагын саналыг үндэслэн хүүхдийн хөгжлийн үйлчилгээний ангилал тус бүрээр төлөвлөн, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлнэ.

5.2.Аргачлалын 5.1-д заасан ирүүлсэн төсвийн саналыг холбогдох төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлнэ.

5.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 6 дугаар сарын 20-ны дотор Засгийн газарт хүргүүлнэ.

5.4.Төсвийн тухай хуулийн 8.3.3-т заасны дагуу Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор батална.

5.5.Аймаг, дүүрэгт хэрэгжүүлэх хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний төсвийн хуваарилалтыг дараах байдлаар хийнэ.

5.5.1.Тухайн жилийн хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийн батлагдсан төсвөөр санхүүжүүлэх боломжит нийт хүүхдийн тоог аргачлалын 2.2-д заасан бүлгийн хүүхдийн давхардал арилгасан тоонд хуваан санхүүжилт хуваарилах хувийг тооцон гаргана.

5.6.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг зохион байгуулж буй байгууллага нь хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх байгууллага, багштай аргачлалын 2.7 дахь хавсралтад заасан 4 талт гэрээг байгуулна.

5.7.Гэрээ байгуулсны дараа үйлчилгээ үзүүлэх байгууллага, иргэнд олгох нийт төсвийн санхүүжилтийн 70 хүртэлх хувийг гэрээний заалтад үндэслэн шилжүүлнэ.

5.8.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний санхүүжилтийн үлдэгдэл 30 хувийг дараах баримт нотолгоонд үндэслэн үйлчилгээ үзүүлсэн байгууллага, иргэнд шилжүүлнэ:

5.8.1.хүүхдийн ирцийн бүртгэл;

5.8.2.хүүхдийн өсөлт хөгжилд гарсан ахицын үнэлгээ;

5.8.3.хүүхэд, эцэг эхээс авах сэтгэл ханамжийн үнэлгээ.

5.9.Хүүхдийн өсөлт хөгжилд гарсан ахицыг “MNS 7076:2025 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”-ын В хавсралтад заасан 6-18 насыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

5.10.Нийгмийн ажилтан болон үйлчилгээ үзүүлэгч байгууллага, багш хүүхдийн нийгэмшихүй, суралцах чадвар, оролцоо, харилцаа, зан төлөв, бие бялдар, таних мэдэхүйн ур чадварт гарсан өөрчлөлтийг ажиглалт, ярилцлагын хэлбэрээр үнэлж, дүгнэж болно.

5.11.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхдээс аргачлалын 2.5, 2.6 дахь хавсралтад заасан маягтаар сэтгэл ханамжийн үнэлгээ авч, тус бүр 20 хүртэл оноогоор үнэлэн баталгаажуулна.

5.12.Аргачлалын 5.11-д заасан сэтгэл ханамжийн үнэлгээний дундаж нь 10 онооноос доош тохиолдолд тухайн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад санхүүжилтийн үлдэгдэл 30 хувийг олгохгүй.

5.13.Хүүхэд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд үйлчилгээг тасралтгүй авах бөгөөд хүүхдийн ирцийн мэдээллийг хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлж буй байгууллага, багшийн зүгээс энэ аргачлалын 6.1-д заасан мэдээллийн санд тогтмол бүртгэнэ.

5.14.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны төсвийн хуваарилалтыг тухайн оны эхний улиралд багтаан боловсруулан, батлуулж, гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

5.15.Нэг жилд зуслангийн үйл ажиллагаанд хамрагдах хүүхдийн тоонд суурилсан төсвийн хуваарилалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хүүхдийн тооны хязгаарын дагуу хэрэгцээнд үндэслэн хуваарилна.

5.16.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн үйлчилгээний зардлын нормативаас давсан зардлыг эцэг эх, асран хамгаалагч хариуцна.

5.17.Боловсрол, соёл, спортын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчид нь хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээг

өөрийн салбарын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэхэд энэ аргачлал, үйлчилгээний зардлын нормативыг мөрдөнө.

Зургаа.Салбар дундын мэдээллийн сан

6.1.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хэрэгжилтийг ил тод, үр ашигтай зохион байгуулах зорилгоор мэдээллийн сан ажиллуулна.

6.2.Мэдээллийн сан нь хүүхдийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн мэдээлэл, ирц, ахицын үнэлгээ, сэтгэл ханамжийн үр дүн ба санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээллийг нэгтгэн харуулна.

6.3.Мэдээллийн санд хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлж буй байгууллага нь хүүхдийн үйлчилгээний ирц, ахицын үнэлгээтэй холбоотой мэдээллийг оруулна. Хүүхдийн ирцийн мэдээллийг тухайн өдөрт нь, хүүхдийн ахицын мэдээллийг сар бүрийн төгсгөлд тус тус оруулна.

6.4.Мэдээллийн сангийн ерөнхий удирдлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцаж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээнэ.

Долоо.Хяналт-шинжилгээ ба үнэлгээ

7.1.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний санхүүжилтийн зарцуулалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд энэ аргачлал, зардлын нормативыг баримтална.

7.2.Сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан болон сургуулийн нийгмийн ажилтан хүүхдийн хөгжлийн үйлчилгээний хэрэгжилтийг анхан шатанд хянах ба ирцийн мэдээлэл, сэтгэл ханамжийн судалгаа, хүүхдийн нийгэмшихүй, суралцах чадвар, оролцоо, харилцаа, зан төлөв, бие бялдар, таних мэдэхүйн ур чадварт гарсан ахиц өөрчлөлт зэргийг ажиглалтын мэдээлэлд үндэслэн хянана.

7.3.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь үйлчилгээ үзүүлж буй байгууллага, иргэнийг “MNS 7076:2025 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”-ын 8.2-т заасны дагуу үе шаттай үйлчилгээ үзүүлж байгаад хяналт тавина.

7.4.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллага нь нийт хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдалтын байдал, төлөвлөсөн ба хамрагдсан хүүхдийн тооны зөрүүнд хяналт тавих замаар хөгжлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлж, тус аргачлал, зардлын нормативын дагуу зарцуулалтын тайланг сар бүрийн 25-ны өдрийн дотор Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнана.

7.5.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хагас жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг 06 дугаар сарын 25, 12 дугаар сарын

25-ны өдрийн дотор Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.6.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж жилд 1 удаа хяналт, шалгалт хийнэ.

Найм.Бусад

8.1.Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, “MNS 7076:2025 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартад нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, гэрээний үүргээ биелүүлээгүй иргэн, байгууллага, хуулийн этгээдийн санхүүжилтийг зогсоож, учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

8.2.Баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, бүрдүүлсэн бол учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.3.Аргачлалын Зургадугаар бүлгийг 2026 оны 1 дүгээр улирлаас хэрэгжүүлнэ.

*Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын сайд,
Сангийн сайдын 2026 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн А/22, А/30,
А/36 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт*

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН НОРМАТИВ

1.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний нэг хүүхдэд нэг сард ногдох зардлын нормативын хэмжээ (төгрөг)

Д/д	Зардлын төрөл	Улсын төсвөөс хариуцах	
		Зардлын норматив	Зардлын норматив
		/Төрийн байгууллагын/	/Төрийн бус байгууллагын/
1.	Хүүхдийн бие махбодын хөгжлийг дэмжих үйлчилгээ	85,000	110,000
2.	Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ	78,000	103,000
3.	Нийгэмшихүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ	62000	87000

2.Хүүхдийн зуслангийн нэг хүүхдэд нэг хоногт ногдох зардлын нормативын дээд хэмжээ (төгрөг)

Д/д	Зардлын төрөл	Нэг удаа
	Зуслан /нэг өдрийн/	67,000

3.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлын нормативт тооцох өсөн нэмэгдүүлэх итгэлцүүр

Байршлын итгэлцүүр	Нийслэлийн	1.1
	Орон нутгийн	1

Хавсралт 2.1. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдах хүүхдүүдийг шалгуурын дагуу үнэлэх аргачлал

	Эмзэг байдлын шалгуур							Нийт оноо	Үнэлгээний эрэмбэ
	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)	(8)	
Хүүхдийн нэр	Эрсдэлт нөхцөлд байгаа эсэх (Тийм=1 үгүй=0)	СХТБ-с суллагдсан (Тийм=1 үгүй=0)	Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагддаг (Тийм=1 үгүй=0)	Амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхэд (Тийм=1 үгүй=0)	Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч, гэрч (Тийм=1 үгүй=0)	Дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн хүүхэд (Тийм=1 үгүй=0)	Хөгжлийн бэрхшээлтэй эсэх (Тийм=1 үгүй=0)	3 ба түүнээс дээш хүүхэд нь ЕБС-д хамрагдаж буй өрхийн хүүхэд (Тийм=1 үгүй=0)	
1. Хүүхэд	1	1	0	1	1	1	0	1	6
2. Хүүхэд	1	0	0	1	1	1	0	1	5
3. Хүүхэд	0	1	0	1	0	1	1	0	4
4. Хүүхэд	1	0	0	0	0	1	0	0	2
Нийт	Тус багана дахь утгын нийлбэр оноо	Тус багана дахь утгын нийлбэр оноо	Тус багана дахь утгын нийлбэр оноо	Тус багана дахь утгын нийлбэр оноо	Тус багана дахь утгын нийлбэр оноо	Тус багана дахь утгын нийлбэр оноо	Тус багана дахь утгын нийлбэр оноо	Тус багана дахь утгын нийлбэр оноо	

Заавар

Орон нутгийн хүүхдүүдийг эмзэг байдлын шалгуураар үнэлж нийлбэр оноог тооцсоны дараа, онооны ихээх бага руу буюу буурах дарааллаар байрлуулан харгалзах онооны дагуу 3 түвшний эрэмбэд ангилна. Үүнд:

- 1-р эрэмбэ: 7 ба 6 оноотой хүүхдүүдийг хамруулах ба хөгжлийн үйлчилгээнд нэн тэргүүнд хамруулна.
- 2-р эрэмбэ: 5 ба 4 оноотой хүүхдүүдийг хамруулах ба 1-р эрэмбийн хүүхдүүдийн дараа үйлчилгээнд хамруулна.
- 3-р эрэмбэ: 3 ба түүнээс доош оноотой хүүхдүүдийг хамруулах ба дараагийн ээлжинд үйлчилгээнд хамруулна.

Орон нутгаас хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах боломжтой хүүхдийн тоонд багтаан 1-р эрэмбийн хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай эхний ээлжинд холбоо тогтооно. 1-р эрэмбийн хүүхдүүдээс хөгжлийн үйлчилгээнд бүрэн хамруулсны дараа 2-р эрэмбийн хүүхдүүдтэй холбоо тогтоох байдлаар хүүхдүүдийг эрэмбэ ба жагсаалтын дагуу үйлчилгээнд хамруулна.

Хавсралт 2.2. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний хүчин чадлыг тооцох нь

Сум, хорооны нутаг дэвсгэрт байрлах хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний байгууллагын бүртгэлийн хуудас

1. Ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Бөглөх
Байгууллагын нэр	
Хуулийн этгээдийн хэлбэр	
☐ Улсын ба орон нутгийн өмчит	
☐ Хувийн	
☐ Олон улсын	
☐ Төрийн бус байгууллага	
Байгууллагын хаяг:	
Холбоо тогтоох мэдээлэл	

1.Үйлчилгээний нэр төрөл, хүчин чадлын мэдээлэл

Дугуйлан, секц, сургалтын нэр	Аль төрөлд хамаарах 1.Бие махбодын хөгжил 2.Танин мэдэхүй 3. Нийгэмшихүй	Үйлчилгээний мэдээлэл			Үүнээс төсвийн санхүүжилтээр хамрагдах боломжит хүүхдийн тоо
		Нэг сард хичээллэх боломжтой бүлгийн тоо (1)	Нэг бүлэгт хамрагдах хүүхдийн тоо (2)	Нийт хамруулах боломжит хүүхдийн тоо (3)=(1)+(2)	
Жишээ: Жудогийн секц	1	3	10	30	10

2.Хүний нөөц, мэргэшсэн сургагч/багшийн мэдээлэл

Багш/сургагчийн тоо	
---------------------	--

3.Дэд бүтэц

Үйлчилгээний байр, талбайн хэмжээ	
Нэг хүүхдэд ноогдох талбайн хэмжээ	

5. Чанарын баталгаажуулалт

Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй эсэх	
Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандартын шаардлага хангасан эсэх	

6. Нэмэлт мэдээлэл

Тусгай хэрэгцээтэй хүүхэд хүлээн авах боломжтой эсэх	
--	--

Хавсралт 2.3

	Байгууллагын нэр	Хөгжлийг дэмжих үйлчилгээний нэр төрөл						Нийт дугуйлан, секцийн тоо (7)=(1)+(3)+(5)	Хамруулах боломжтой хүүхдийн тоо (8)=(2)+(4)+(6)
		Бие махбодын хөгжлийг дэмжих үйлчилгээ		Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ		Нийгэмлэхийн хөгжлийг дэмжих үйлчилгээ			
		Дугуйлан, секцийн тоо (1)	Хамруулах боломжтой хүүхдийн тоо (2)	Дугуйлан, секцийн тоо (3)	Хамруулах боломжтой хүүхдийн тоо (4)	Дугуйлан, секцийн тоо (5)	Хамруулах боломжтой хүүхдийн тоо (6)		
1.	Байгууллага 1	5	30	0	0	0	0	5	30
2.	Байгууллага 2	-	-	6	80	2	40	8	120
	Нийт								

*Хавсралт 2.4. Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид
мэдээлэл хүргэж, зөвшөөрөл авах*

**А. Хүүхдийг хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулах талаар
эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдээлэл илгээх
хуудас**

Хүндэт _____ (эцэг эх/асран
хамгаалагч/ харгалзан дэмжигчийн нэр) танд,

Таны хүүхэд _____ (хүүхдийн
нэр)-г орон нутгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн
асуудал хариуцсан байгууллагаас хийсэн үнэлгээгээр төрөөс санхүүжих
хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдах боломжтой болохыг
мэдэгдэж байна.

Таны хүүхэд хөгжлийг дэмжих дараах үйлчилгээнд хамрагдах
боломжтой:

- Үйлчилгээний нэр, төрөл: _____
- Хугацаа: _____
- Хамрагдах газар, байгууллага: _____

Анхаарах зүйлс:

1. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зардлыг улсын болон
орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бөгөөд эцэг эх, асран
хамгаалагч нь эхний сарын төлбөрийн 10 хувийг үйлчилгээ
үзүүлэх байгууллагад шилжүүлэх үүрэгтэй. Энэ нь хүүхдийг
үйлчилгээнд албан ёсоор хамруулах үндэслэл болно.
2. Хүүхдийнхээ нас, сэтгэхүйн онцлогт тохируулан дурдсан
үйлчилгээнд хамрагдах талаар хүсэл сонирхлыг нь асууж
тодруулж ярилцсаны үндсэн дээр хүүхэдтэйгээ хамтран
шийдвэр гаргана.
3. Хүүхдийг үйлчилгээнд хамруулах тохиолдолд тасалдуулахгүй
явуулах хэрэгтэй ба ирцийн бүртгэл, оролцоо, ахиц дэвшлийг
тогтмол хянаж, хүүхдийн өсөлт хөгжилд гарч буй ахиц
дэвшлийг баталгаажуулсны үндсэн дээр үлдэгдэл санхүүжилт
олгогдоно.

Таны хийх алхам:

- Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш _____ ны дотор
(ажлын 5 хоногийн дотор) шийдвэр гаргаж, дараагийн хуудсан
өгөгдсөн зөвшөөрлийн маягтыг бөглөн бидэнд илгээнэ үү.

Та нэмэлт мэдээлэл авах бол дараах утсаар бидэнтэй холбогдоно уу

- Утас: _____

Хүндэтгэсэн,

.....

(Нийгмийн ажилтан, байгууллагын нэр, гарын үсэг)

Б. Хүүхдийг төрийн санхүүжилтээр хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулах талаар эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийн хуудас

Би, _____ (эцэг эх/асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн нэр), _____ (хүүхдийн нэр)-г орон нутгаас санал болгож буй хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулах талаар дараах шийдвэр гаргав.

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн шийдвэр (Дараах хоёр шийдвэрийн аль нэгийг сонгоно уу)

- ☐ **Би дараах нөхцөлийг ойлгосны үндсэн дээр хүүхдээ санал болгож буй үйлчилгээнд хамруулахыг зөвшөөрч байна.**
- ☐ Хүүхэд үйлчилгээнд тогтмол, тасралтгүй хамрагдах шаардлагатай.
 - ☐ Хүүхдийн ирц, оролцоо, ахиц дэвшил тогтмол бүртгэгдэж, энэ нь санхүүжилтийн нөхцөлд нөлөөлнө.
 - ☐ Хүүхэд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр олон удаа тасалсан тохиолдолд санхүүжилт болон хамрагдах эрх цуцлагдах боломжтой.
 - ☐ Эцэг эх/асран хамгаалагчийн хувьд хүүхдийн бэлтгэлийг хангах, цагт нь авч ирэх, багшид мэдээлэл өгөх зэрэг хамтын оролцоог хариуцна.
 - ☐ Үйлчилгээний эхний төлбөрийн 10%-ийг хугацаанд нь төлөх үүрэгтэй.
- ☐ **Хүүхдээ үйлчилгээнд хамруулахаас дараах шалтгаанаар татгалзаж байна. Хэд хэдэн шалтгаан сонгож болно.**
- ☐ Хугацааны хувьд тохиромжгүй.
 - ☐ Үйлчилгээний төрөл нь хүүхдийн сонирхол, хэрэгцээнд тохироогүй.
 - ☐ Өрхийн санхүүгийн хүндрэл
 - ☐ Хүүхдийг үйлчилгээнд зөөх хүн байхгүй.
 - ☐ Үйлчилгээний байгууллагын байршил хол, алслагдмал байна.
 - ☐ Эрүүл мэндийн шалтгаан (хүүхдийн өвчлөл, хөгжлийн онцлог)
 - ☐ Өмнө нь ижил үйлчилгээ авсан.
 - ☐ Бусад:

Эцэг эх/асран хамгаалагчийн нэр: _____

Гарын үсэг: _____

Огноо: _____

Хавсралт 2.5 Сэтгэл ханамжийн үнэлгээний загвар

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс авах сэтгэл ханамжийн асуулгын хуудас

Та хүүхдийнхээ хамрагдсан үйлчилгээг дараах шалгуурын дагуу үнэлнэ үү

Хүүхдийн хамрагдсан үйлчилгээний мэдээлэл

№	Шалгуур үзүүлэлт	Оноо
		Маш сайн = 5 Сайн = 4 Дунд =3 Муу =2 Маш муу =1
1.	Үйлчилгээний орчин нөхцөл, тав тух, хүүхдэд ээлтэй байдлыг та хэрхэн үнэлэх вэ?	 (оноо)
2.	Багш, ажилтнуудын харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлэх вэ?	 (оноо)
3.	Хүүхдийн тань хөгжилд гарсан ахиц, үр дүнг хэрхэн үнэлэх вэ?	 (оноо)
4.	Үйлчилгээний цаг хугацаа, төлөвлөлт, зохион байгуулалтыг та хэрхэн үнэлэх вэ?	 (оноо)

Нийт оноо: (___ / 20)

Тус дугуйлан, секц цаашид юунд анхаарах хэрэгтэй гэж үзэж байна вэ?

Хавсралт 2.6 Хүүхдээс авах сэтгэл ханамжийн үнэлгээний маягт

Чи энэ дугуйлан/үйлчилгээнд хамрагдсандаа хэр сэтгэл хангалуун байна вэ?

№	Шалгуур үзүүлэлт	Оноо
		Маш сайн = 5 Сайн = 4 Дунд =3 Муу =2 Маш муу =1
1.	Энэ дугуйлан, секц чамд хэр таалагдсан бэ?	 (оноо)
2.	Дугуйлан, секцийн үйл ажиллагаа чамд хэр сонирхолтой байсан бэ?	 (оноо)
3.	Энэ дугуйлан, секцэд явснаар шинэ зүйл сурч мэдсэн үү?	 (оноо)
4.	Анги танхимын тохижилт, орчин нөхцөл ямар байсан бэ?	 (оноо)

*Хавсралт 2.7 Хүүхдийг хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулах
талаар талуудын хооронд байгуулах гэрээний загвар*

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 4 ТАЛТ ГЭРЭЭ

№ _____

_____ аймаг/дүүрэг, _____ сум/хороо

Нэг.Нийтлэг үндэслэл

Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн конвенц болон холбогдох бусад хууль тогтоомж, “MNS 7076:2025 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандарт тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журмыг удирдлага болгов.

Энэхүү гэрээний зорилго нь хүүхдийг хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулах, төлбөрийн зохицуулалт, талуудын эрх, үүргийг тодорхойлох, үйлчилгээний чанар, санхүүжилт болон хяналт-шинжилгээний зарчмыг хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр.Гэрээний талууд

Энэхүү гэрээг дараах талуудоны.....сарын.....-ний өдөр харилцан тохиролцож байгуулав.

2.1.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч:
_____ (РД: _____, хаяг: _____)

_____, утас: _____)
2.2.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага:
_____ (Төлөөлөгч: _____, албан тушаал: _____)

2.3.Үйлчилгээ үзүүлэх байгууллага: _____
(Хуулийн этгээдийн нэр, РД: _____, хаяг: _____)

2.4.Багш: _____
(Холбоо барих: _____)

Гурав.Гэрээний нөхцөл

3.1.Хүүхдийн нэр: _____ (РД: _____)

3.2.Үйлчилгээний төрөл:

- ☐ Бие махбодын хөгжлийг дэмжих:
- ☐ Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих
- ☐ Нийгэмшихүйн хөгжлийг дэмжих
- ☐ Хүүхдийн зуслан

3.3.Үйлчилгээний үргэлжлэх хугацаа: _____ сараас _____
сар хүртэл.

3.4.Үйлчилгээний төлбөрийн хэмжээ: _____ төгрөг.

Улсын төсвөөс хариуцах: _____ төгрөг

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хариуцах:
_____ төгрөг (анхны 10% дүнг эхний шатанд шилжүүлнэ).

Дөрөв.Гэрээнд оролцогч талуудын нийтлэг эрх, үүрэг

4.1.Хүүхдийн сурч хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.Хүүхдийн ялгаатай байдлыг ойлгож, дэмжин туслах замаар хүүхдийн хөгжлийг дэмжих;

4.3.Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэл, хорт зуршил, болзошгүй осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг нь тогтмол сахин хамгаалах;

4.4.Асуудлыг шийдвэрлэхдээ талууд бие биедээ хүндэтгэлтэй хандаж, бусдын нэр хүндийг гутаан доромжилсон үг хэллэг, үйлдлийг санаатай болон санамсаргүй байдлаар гаргахгүй байх, ёс зүйтэй байх.

Тав.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг

5.1.Сургалт, дугуйлан, секцийн хуваарийн дагуу хөгжлийг дэмжих үйлчилгээнд бүрэн хамруулах, өдөр тутмын бэлтгэлийг хангах, хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд багшид цаг тухай бүрд нь заавал мэдэгдэх;

5.2.Гэрээний дагуу хүлээсэн төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлэх;

5.3.Хүүхдийн оршин суугаа газар, гэрийн хаяг, холбоо барих утас, бусад мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд багшид тухай бүр мэдэгдэх;

5.4.Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийн онцлог, чадварыг харгалзан тухайн хүүхдэд шаардагдах нэмэлт хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн туслалцаа дэмжлэг үзүүлэх (нүдний шил, цагаан таяг, тэргэнцэр г.м.);

5.5.Гэр бүлийн орчинд сурч хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, багштай хамтран ажиллах;

5.6.Суралцагчийн хувийн мэдээллийг үнэн зөв мэдүүлэх, мэдээлэл үнэн зөв бүртгэгдэн хөтлөгдөж байгаа эсэгт хяналт тавих, шаардлагатай тохиолдолд засварлуулах.

Зургаа.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын эрх, үүрэг

6.1.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний санхүүжилтийн зохицуулалтыг хийх;

6.2.Үйлчилгээний явцад хяналт тавих, тайлан, дүн шинжилгээ хийх;

6.3.Хүүхдийн хамрагдалтын ирц, ахицын үнэлгээнд үндэслэн үлдэгдэл санхүүжилтийг баталгаажуулах.

Долоо.Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх байгууллагын эрх, үүрэг

7.1.Хүүхдийн нас, сэтгэлзүй, хөгжлийн онцлогт нийцсэн үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх;

7.2.Гэрээнд заасан хугацаа, хөтөлбөрийн дагуу тогтмол үйлчилгээ үзүүлэх;

7.3.Хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээ, тайланг гаргаж, хариуцсан байгууллагад хүргүүлэх;

7.4.Хүүхдийн эрхийг хүндэтгэн, холбогдох стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх.

Найм.Багш/мэргэжилтний эрх, үүрэг

8.1.Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах, зөвлөн туслах;

8.2.Хүүхдийн хэрэгцээ, шаардлагад хүндэтгэлтэй хандах /ариун цэврийн өрөө орох, цэвэр ус уух боломжоор хангах, агаар сэлгэлт хийх г.м/;

8.3.Хүүхдэд үзүүлж буй хөгжлийн үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр эцэг, эх асран хамгаалагчдыг хангах;

8.4.Бага ангийн суралцагч болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг заавал эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүлээлгэн өгч, хүлээн авах;

8.5.Хүүхдийг хүндэтгэх, бие даасан байр суурь, үзэл бодол, онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч зөв хандлагаар чиглүүлж, хөгжүүлэх;

8.6.Хичээл сургалтын үйл ажиллагаа бүрд хүүхдийн ирцийг тогтмол бүртгэх;

8.7.Хүүхэд тухайн өдөр үйлчилгээнд ирээгүй тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид заавал мэдэгдэж, шалтгааныг тодруулах;

8.8.Сургалт, үйл ажиллагааны үеэр хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, тэдний аюулгүй байдлыг хангах;

8.9.Хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн мэдлэг, боловсрол, хэл, соёл, яс үндэс, ажил эрхлэлт, албан тушаал, амьжиргааны түвшин зэрэг ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандаж, соёлтой харилцах;

8.10.Хүүхдийн ахиц, хөгжлийн үнэлгээг сар бүрийн төгсгөлд гаргах;

8.11.Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн хөгжил, дэвшлийн талаарх мэдээллийг тогтмол өгөх;

8.12.Үйлчилгээний чанарт хяналт тавихад хамтран ажиллах.

Ес.Санхүүжилт ба тооцоо

9.1.Гэрээ байгуулсны дараа үйлчилгээ үзүүлэх байгууллага, иргэнд олгох нийт төсвийн санхүүжилтийн 70 хүртэлх хувийг гэрээний

заалтад үндэслэн шилжүүлнэ.

9.2.Үлдэгдэл санхүүжилт нь хүүхдийн ирцийн бүртгэл, ахицын үнэлгээнд үндэслэн олгогдоно.

9.3.Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс авах сэтгэл ханамжийн үнэлгээний оноо 10-аас доош гарсан тохиолдолд үлдэгдэл 30%-ийг олгохгүй.

Арав.Хяналт, үнэлгээ

10.1.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын мэргэжилтэн үйлчилгээнд хяналт тавина. Үүнд:

10.1.1.Хүүхдийн ирцийн мэдээллийг тогтмол хүлээн авна;

10.1.2.Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамжийн үнэлгээг сар бүрийн төгсгөлд авна;

10.1.3.Сард 1-2 удаа байгууллагад очиж үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавина.

10.2.Хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг багш үйлчилгээний төгсгөлд үнэлж, дүнг тайлагнана.

Арван нэг.Хариуцлага

11.1.Аль нэг тал гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

11.2.Үйлчилгээ үзүүлэгч тал гэрээний заалтыг зөрчсөн бол санхүүжилтийг зогсоож, авсан хөрөнгийг нөхөн төлүүлнэ.

11.3.Багш ирц, ахицын үнэлгээг үнэн зөв бүртгээгүй нь тогтоогдвол гэрээг цуцлах үндэслэл болно.

Арван хоёр.Гэрээний хугацаа

Энэхүү гэрээ нь гарын үсэг зурсан өдрөөс эхлэн _____ он, _____ сар, _____ өдөр хүртэл хүчинтэй байна.

Арван гурав.Гарын үсэг

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч
Гарын үсэг: _____

Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага
Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан: _____

Үйлчилгээ үзүүлэх байгууллага
Захирал: _____

Багш
Гарын үсэг: _____

*Хавсралт 2.8 Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний
хэрэглэгдэхүүний жагсаалт*

Үйлчилгээний төрөл	Хэрэглэгдэхүүний жишээ
Бие махбодын хөгжлийг дэмжих үйлчилгээ	Спортын бөмбөг (сагсан бөмбөг, хөл бөмбөг, гар бөмбөг) Дасгалын хэрэгсэл (гантель, сунгалтын резин, фитнесийн жижиг тоног төхөөрөмж) Хамгаалах хэрэгсэл (дуулга, өвдгөвч, тохойвч, хамгаалалтын малгай) Спортын хувцас, гутал, бүжгийн хувцас, чийрэгжүүлэлтийн хэрэгсэл Йога, гимнастикийн дэвсгэр, бүжгийн дагалдах хэрэгсэл, хувцас
Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ	Ном, сэтгүүл, сурах бичиг, гарын авлага Шатрын самбар, даалгаврын ном, оюун ухааны тоглоом Роботикс, электроникийн иж бүрдэл (Arduino, Lego, мэдрэгч, мотор, эд анги) Лабораторийн жижиг багаж хэрэгсэл (туршилтын хэрэгсэл, шилэн сав, микроскоп) Цахим хэрэглэгдэхүүн (компьютерын програм, сургалтын аппликейшн, онлайн багц) Зургийн самбар, зураглалын хэрэгсэл, код бичих сургалтын материал
Нийгэмшихүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ	Хөгжмийн зэмсэг (төгөлдөр хуур, гитар, лимбэ, бөмбөр, жижиг хөгжмийн хэрэгсэл) Дуу, жүжгийн тайзны хэрэгсэл (микрофон, чанга яригч, гэрэлтүүлгийн жижиг төхөөрөмж) Урлагийн материал (зурах хэрэгсэл, өнгийн будаг, цаас, даавуу, шавар, баримлын материал) Эко клубын хэрэгсэл (тарьц суулгац, хүрз, усалгааны сав, хамгаалалтын бээлий, хувин) Жүжиг, бүжгийн хувцас, дүрслэх урлагийн хэрэглэгдэхүүн

Хавсралт 2.9

Мэргэшсэн багшийн хөлс:

Нэг багш хэдэн хүүхэдтэй ажиллах нь сургалтын төрөл, ангийн хэмжээ, багшийн ачааллаас хамаарна. Жишээлбэл:

- Спортын секц - 15-20 хүүхэд
- Урлагийн дугуйлан - 10-15 хүүхэд
- Нийгэмшихүйн сургалт - 15 орчим хүүхэд

Багшийн хөлсний хувийг жишиг байдлаар 50-60% гэж авсан.

Жишиг тооцоо /төрийн байгууллагын жишээн дээр/

Хүүхдийн бие махбодын хөгжлийг дэмжих үйлчилгээ

- Нэг хүүхдийн норматив (төрийн байгууллагаар): 85,000₮
- Үүнээс багшийн хөлс: 51,000₮ (60%)

Хэрэв нэг багш 15 хүүхэдтэй ажиллавал:

$$51,000 \times 15 = 765,000₮ / \text{сар}$$

Хэрэв нэг багш 20 хүүхэдтэй ажиллавал:

$$51,000 \times 20 = 1,020,000₮ / \text{сар}$$

Танин мэдэхүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ

- Нэг хүүхдийн норматив (төрийн байгууллагаар): 78,000₮
- Үүнээс багшийн хөлс: 42,900₮ (55%)

$$15 \text{ хүүхэдтэй үед: } 42,900 \times 15 = 643,500₮ / \text{сар}$$

$$20 \text{ хүүхэдтэй үед: } 42,900 \times 20 = 858,000₮ / \text{сар}$$

Нийгэмшихүйн хөгжлийг дэмжих үйлчилгээ

- Нэг хүүхдийн норматив (төрийн байгууллагаар): 62,000₮
- Үүнээс багшийн хөлс: 31,000₮ (50%)

$$15 \text{ хүүхэдтэй үед: } 31,000 \times 15 = 465,000₮ / \text{сар}$$

$$20 \text{ хүүхэдтэй үед: } 31,000 \times 20 = 620,000₮ / \text{сар}$$

Дүгнэлт

- Нэг мэргэшсэн багшийн сарын орлого нь 465,000₮ - 1,020,000₮ орчим байх боломжтой.
- Төрийн бус байгууллагын норматив өндөр тул багшийн цалин 20-30% илүү гарах боломжтой.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ТОНХИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 1 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 07

Зүйл

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.15, 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Малын тоо толгойн албан татварын хэмжээг шинэчлэн, хавсралтаар баталснаар тогтоосугай.

2.Малын тоо толгойн албан татварыг батлагдсан хувь хэмжээний дагуу хуульд заасан хугацаанд орон нутгийн төсөвт төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнан ажиллахыг сумын Засаг дарга (Ч.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (Н.Бямбабадам)-д даалгасугай.

4.Уг тогтоолыг захиргааны хэм хэмжээний хүчин төгөлдөр актаар бүртгэгдсэн өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ГАНТУЛГА

*Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 1 дүгээр сарын
30-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралт*

**МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТӨРӨЛ ТУС БҮРИЙН
ХЭМЖЭЭ**

Д.д	Малын төрөл	Татварын хэмжээ /Төгрөгөөр/
1.	Адуу	500
2.	Үхэр	500
3.	Хонь	500
4.	Ямаа	500
5.	Тэмээ	0

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 09

Ар-Асгат

ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 7 сарын 19-ний өдрийн 192,А/243 дугаар тушаалын 1 дүгээр хавсралыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит зургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хавсралтаар баталсугай.


2.Тогтоолоор баталсан төлбөрийг сумын хог хаягдлын үйлчилгээний санд төвлөрүүлж, хууль тогтоомжийн дагуу зарцуулан, төв суурин газрын орчны эрүүл ахуйг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Энхболд)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Болор-Эрдэнэ), хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн (Б.Амарзаяа) нарт үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 6 дугаар сарын 21-ний 06 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Л.АМАРСАНАА



1

ਸ਼੍ਰੋਮਣੀ - ਅੰਮ੍ਰਿਤਸਰ



*Төв аймгийн Угтаалцайдам сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит зургаадугаар
хуралдааны 09 дүгээр тогтоолын хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

2025.12.16

Ар-Асгат

№	Нэрс	Сард төлөх дүн /төг/	Жилд төлөх дүн /төг/
1	Иргэн	500	6000
2	Төсөвт байгууллагууд	10,000	120,000
3	ААН, ХААКТӨХХК /газар тариалан эрхлэгч компани/	20,000	240,000
4	Бусад ААН /арилжааны банк, ШТС, Эрчим хүч, Мал эмнэлэг, цаг уур /	16,000	192,000
5	Үйлчилгээний газар /хүнс барааны дэлгүүр, цайны газар, оёдол, эмийн сан, үсчин, дугуй засвар, цахилгаан засвар, гутал засвар, халуун ус/	15,000	180,000
6	Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч, Ану-сервис ХХК	70,000	840,000

УВС АЙМАГ ЗҮҮНГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 12 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 7/02

Зэлийн гол

ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 41-р зүйлийн 41.5, 41.6 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.2 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан үнэ тарифын дагуу иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаас хураан барагдуулж орон нутгийн төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлэх, хагас бүтэн жилээр биелэлт үр дүнг нь танилцуулж, зохих журмын дагуу зарцуулж, тайланг гаргаж ажиллахыг сумын Засаг дарга (М.Туяа)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2016 оны 12 дүгээр сарын 19-ны өдрийн 02/09 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ж.Баянтөр), байгаль орчны бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн (Б.Буянбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

П.БУЯНДАЛАЙ

*Сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн
7 дугаар хуралдааны тогтоолын 7/02 дугаар хавсралт*

Сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын хураамжийн хэмжээ

Д/д	Хог хаягдлын эх үүсвэр	Тооцох нэгж	Үйлчилгээний хураамж
1	Айл өрх/1 ам бүл/	Сар бүр	300
2	Банк, санхүүгийн байгууллага	Сар бүр	11000
3	Буудал	Сар бүр	11000
4	Дугуй засвар, засвар үйлчилгээ	Сар бүр	10000
5	Шатахуун түгээх станц	Сар бүр	25000
6	Байшин барьж байгаа болон засвар хийж байгаа айл өрх	Сар бүр	4500
7	Дэлгүүр	Сар бүр	6000
8	Дэлгүүр /тусгай зөвшөөрөлтэй/	Сар бүр	8000
9	Кафе, Гуанз	Сар бүр	10000
10	Албан байгууллага	Сар бүр / 1 ажилтан/	1000
11	Сумын төвд байгаа Малтай өрх	Сар бүр Бод /тоо тутамд/	400
		Сар бүр Бог /тоо тутамд/	200
12	Аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулдаг ААНБ, иргэн	Ажилласан хугацаанд сард	100000
13	Мал нядалгааны газар болон хашаандаа мал нядалж байгаа	Сард /Бог тоо тутамд/	500
		Сард /Бод тоо тутамд/	1000
14	Уурын зуух	Ажиллах хугацаанд /Сар бүр /	125000
		Бусад үед /Сар бүр/	60000
15	Мал эмнэлэг	Сард	2000
16	Явуулын худалдаа, үйлчилгээ	Сард	20000
17	Ноос, эсгий, блокны үйлдвэр	Ажилласан хугацаандаа сар бүр	10000
18	Халуун ус	сардаа	10000

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 7559 дүгээрт бүртгэв.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 1 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.11, 10.2, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Бусдын эзэмшлийн шугам сүлжээ, дамжуулан шахах насосын станцаар цэвэр ус түгээх, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах нөхцөлд хангагч, шугам сүлжээ эзэмшигчдийн хооронд хийх төлбөр тооцооны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, зохих журмын дагуу нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд мэдээллэх ажлыг зохион байгуулахыг Үнэ тариф, судалгааны газар /Б.Доржбат/-д даалгасугай.

ДАРГА

Г.ЦОГТСАЙХАН

ГИШҮҮН

Б.АЛТАНТУУЛ
Д.АНХБАТ
Ц.БАТЗАЯА
Т.УЛАМБАЯР

*Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт,
үйлчилгээг зохицуулах хорооны 2026 оны 1 дүгээр сарын 27-ны
өдрийн 15 дугаар тоот тогтоолын хавсралт*

БУСДЫН ЭЗЭМШЛИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ, ДАМЖУУЛАН ШАХАХ НАСОСЫН СТАНЦААР ЦЭВЭР УС ТҮГЭЭХ, ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ НӨХЦӨЛД ХАНГАГЧ, ШУГАМ СҮЛЖЭЭ ЭЗЭМШИГЧДИЙН ХООРОНД ХИЙХ ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Энэхүү журмыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10.1.11 дүгээр зүйл, “Цэвэр, бохир усны үйлчилгээний тариф, төлбөр тооцох аргачлал”, мөн “Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ийг тус тус үндэслэн боловсруулсан болно.

1.2.Энэхүү журмын зорилго нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд /цаашид ТЗЭ гэх/ хооронд шугам сүлжээ, шахах насосын станцаар дамжуулан цэвэр ус түгээх, бохир ус татан зайлуулах үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд үүсэх төлбөр тооцооны харилцааг зохицуулахад оршино.

1.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, дамжуулан шахах насосын станцаар бусад ТЗЭ-ийн цэвэр усыг дамжуулан хэрэглэгчдэд хүргэх, бохир усыг “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ /цаашид УСУГ гэх/-ын төвлөрсөн шугамд нийлүүлэх тохиолдолд гарах нэмэлт зардлыг хэрхэн тооцож, хуваарилахад ашиглана.

Хоёр. Төлбөр тооцуулах хүсэлт ирүүлэх

2.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшлийн шугам сүлжээ болон өргөлтийн насосын станцаар бусад ТЗЭ-ийн цэвэр, бохир усыг дамжуулж байгаа тохиолдолд хүсэлтийг албан бичгээр ирүүлнэ.

2.2.Хүсэлт ирүүлэхдээ дараах материалуудыг хавсаргана.

- Шугам сүлжээ болон насосын бүрэн мэдээлэл /Шугамын диаметр, материал, урт, насосын загвар марк, хүчин чадал, хоногт хэдэн цаг ажилладаг г.м/
- Шугам сүлжээ болон насос ажиллуулснаар гарч буй зардлын тооцоо, баталгаажуулах баримт
- Шугам сүлжээ болон насосын станцаар дамжих усны хэрэглээний тооцоо /үйл ажиллагаа нь явагдаж буй ТЗЭ-ийн хувьд сүүлийн 1 жил, дараа жилийн төлөвлөгөө, шинэ ТЗЭ-ийн хувьд дараа жилийн төлөвлөгөө/

Гурав. Төлбөр тооцоолох

3.1.Тухайн шугам сүлжээ болон насосын станцаар дамжих нийт усны хэрэглээг хангагч байгууллагаас тодруулж, байгууллагаас ирүүлсэн баримтыг хянах,

3.2.Шугам сүлжээ болон насосын станцаар дамжих нийт усны үйлчилгээний биет хэмжээг дараах томъёогоор тооцно.

$$Q_{\text{нийт}} = \sum_{i=1}^n q_i$$

$Q_{\text{нийт}}$ – шугам сүлжээ болон насосын станцаар дамжих нийт усны хэрэглээ, мян.м³

i – шугам сүлжээ болон насосын станцаар ус дамжуулах ТЗЭ-дийн тоо

q_i – ТЗЭ-дийн хэрэглээний хэмжээ, мян.м³

3.3.Бусдын эзэмшлийн шугам сүлжээ, дамжуулан шахах насосын станцаар дамжих цэвэр, бохир усны төлбөрт доорх зардлыг оруулж тооцно.

$$C_{\text{нийт}} = C_{\text{цалин}} + C_{\text{ашиглалт}} + C_{\text{засвар}} + C_{\text{элэгдэл}}$$

a. $C_{\text{цалин}}$ – Цалингийн зардал: Шугам сүлжээ болон насосын станцад нэмэлтээр оператор, засварчин ажиллуулах эсвэл ажилтан ажил үүргийг хавсран гүйцэтгэснээс хамааран цалин хөлсийг нэмэгдүүлэх шаардлагатай тохиолдолд цалин хөлс түүнтэй холбогдох зардал болон хөдөлмөр хамгааллын зардлыг тусгана.

b. $C_{\text{ашиглалт}}$ – Ашиглалтын зардал: Насосын станц ажиллуулахад шаардагдах цахилгааны зардал, лаг цэвэрлэх, соруулах ажлын зардал

c. $C_{\text{засвар}}$ – Засвар үйлчилгээний зардал: Шугам сүлжээ, насос, тоног төхөөрөмжийн урсгал засвар хийх, жижиг эвдрэлийг засахад шаардлагатай зардал, мөн сэлбэг хэрэгслийн зардлыг тооцно.

d. $C_{\text{элэгдэл}}$ – Элэгдлийн зардал: Элэгдлийн зардлыг тариф тооцох зардалд оруулж тооцсоноор шугам сүлжээ болон насосын станцын эзэмшигч тал их засвар болон хөрөнгө шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.

3.4.Зардлын тооцоог баримт нотолгоонд тулгуурлан, өмнөх жилүүдийн жишиг зардлын хүрээнд Зохицуулах хорооны урьдчилсан хяналтаар баталгаажуулна. Баримтаар баталгаажаагүй, үндэслэлгүй зардлыг төлбөрийн тооцоонд тусгахгүй.

3.5.Гэнэтийн осол, аваарын үед шаардлагатай санхүүжилтийг шугам сүлжээ, дамжуулан шахах насосын станцын эзэмшигч хариуцаж, тоног төхөөрөмжийг яаралтай хэвийн ажиллагаанд оруулна. Гарсан зардлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нийлүүлсэн усны хэрэглээний хувьтай тэнцүү хэмжээгээр тооцож шугам сүлжээ, дамжуулан шахах насосын станцын эзэмшигч нь дамжуулагч ТЗЭ-ээс нэхэмжилнэ.

3.6.Шугам, сүлжээ болон насосын станцаар дамжуулах төлбөрийг тухайн шугам сүлжээ болон насосын станцад гарах нийт зардлыг, тухайн шугам сүлжээ болон насосын станцаар дамжиж буй нийт усны хэрэглээний хэмжээнд хувааж тооцно.

$$T_{\text{дам}} = C_{\text{нийт}} \div Q_{\text{нийт}}$$

3.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрийн сард төлөх төлбөрийн хэмжээг дараах томъёогоор тооцно:

$$C_{\text{ТЗЭ}} = T_{\text{дам}} * q_i$$

3.8.Төлбөрийг батлахаас өмнө Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны ажлын албанаас оролцогч талуудтай нөхцөл байдал, шаардлагын талаар сонсох ажиллагааг зохион байгуулна.

3.9.Бусдын эзэмшлийн шугам сүлжээ, дамжуулан шахах насосын станцаар цэвэр ус түгээх, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах ТЗЭ нь батлагдсан бөөний тарифын дагуу төлбөрийг хугацаанд нь УСУГ-т төлнө. УСУГ нь батлагдсан дамжуулах төлбөрөөр ТЗЭ-ийн хэрэглээг сар бүр тооцож, шугам сүлжээ, насосын станцын эзэмшигч компанийн дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Гэрээ байгуулах

4.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч талууд (шугам сүлжээ болон насосын станц эзэмшигч, дамжуулагч) хооронд цэвэр ус дамжуулах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний гэрээг байгуулна.

4.2.Гэрээ нь Иргэний хууль Хот,суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооноос баталсан Аж ахуйн харилцааны дүрэм, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна»

4.3.Гэрээнд дараах агуулгыг заавал тусгасан байна.

- a. Төлбөрийн нөхцөл
- b. Гэнэтийн осол аваарын үед талуудын хүлээх үүрэг, хариуцлага болон зардлын санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх
- c. Мэдээлэл солилцох /усны хэрэглээний хэмжээ, хугацаа/
- d. Маргаан шийдвэрлэх
- e. Техникийн нөхцөл

Тав. Маргаан шийдвэрлэх

5.1.Талуудын хооронд үүссэн аливаа маргааныг талууд хамтран шийдвэрлэх бөгөөд хэрэв зөвшилцөлд хүрч чадахгүйд хүрвэл Зохицуулах хороонд хандаж шийдвэрлүүлнэ.

5.2.Хэрэв Зохицуулах хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 7560 дугаарт бүртгэв.

БУЛГАН АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 2 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 04

Булган

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын “Эрчим хүчний тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймгийн Булган сумын Рашаант 4-р багийн “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2.Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүртгэгдсэн өдрөөс дагаж мөрдөхийг “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн, дарга /С.Одончимэг/-д даалгасугай.

ДАРГА

С.ОДОНЧИМЭГ

ГИШҮҮН

Г.НАРАНГЭРЭЛ
Г.ГАНТУЛГА

*Булган аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн
2026 оны 04 дүгээр тогтоолын хавсралт*

**БУЛГАН СУМЫН РАШААНТ 4-Р БАГИЙН “ДОЛООН БАР” ХХК-
ИЙН ЭЗЭМШЛИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Булган аймгийн “Долоон бар” ХХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Булган сумын Рашаант 4-р багийн хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын халаалт	төг/м ³	1996
		төг/гДж	42650
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	төг/м ³	1300
		төг/гДж	19210
3	Айл өрх	төг/м ²	900
		төг/гДж	4295

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

“ШҮҮГЧИД ТАВИХ БОЛЗОЛ, ШААРДЛАГЫГ ҮНЭЛЭХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.5 дахь заалт, 79 дүгээр зүйлийн 79.1, 79.5 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-д доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/5.1.2 дахь заалт:

“5.1.2.Энэ журмын 5.1.1.1, 5.1.1.2-т заасан шалгалтын нийлбэр оноо 30 хүрээгүй бол нэр дэвшигч 5.1.1.3-т заасан шалгалтад орох эрхгүй.”

2/5.2.2 дахь заалт:

“5.2.2.Энэ журмын 5.2.1.1, 5.2.1.2-т заасан шалгалтын нийлбэр оноо 30 хүрээгүй бол нэр дэвшигч 5.2.1.3-т заасан шалгалтад орох эрхгүй.”

3/5.3.2 дахь заалт:

“5.3.2.Энэ журмын 5.3.1.1, 5.3.1.2, 5.3.1.3-т заасан шалгалтын нийлбэр оноо 30 хүрээгүй бол нэр дэвшигч 5.3.1.4-т заасан шалгалтад орох эрхгүй.”

4/5.4.7 дахь заалт:

“5.4.7.Энэ журмын 5.1.2, 5.2.2, 5.3.2-т заасан шалгалтын нийлбэр оноог тогтоолоор батална.”

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 5.4.3 дахь заалтын “баримтална.” гэсний дараа “Нэр дэвшигчийн гүйцэтгэлийг үнэлэх ажиллагаанд хөндлөнгийн, хараат бус шинжээчийг оролцуулж болно.” гэж, 8.3 дахь хэсгийн “Нэр дэвшигч энэ журмын 5.4.4,” гэсний дараа “5.4.7,” гэж тус тус нэмсүгэй.

3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын дараах дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5.1.1.1 дэх дэд заалт:

“5.1.1.1.Үндсэн хуулийн болон салбар эрх зүйн мэдлэгийг сорилын асуултад хариулах аргаар 120 минутын хугацаанд шалгах, 20 хүртэл оноогоор үнэлэх.”

2/5.1.1.2 дахь дэд заалт:

“5.1.1.2.салбар эрх зүйн хууль хэрэглэх мэдлэг, чадварыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 30 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр тохиолдол шийдвэрлэнэ. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол нэр дэвшигч эдгээр салбар эрх зүйн аль чиглэлээр тохиолдол шийдвэрлэхийг өөрөө сонгоно.”

3/5.1.1.3 дахь дэд заалт:

“5.1.1.3.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх тухайлсан хуулийг хэрэглэх мэдлэг, чадварыг эрх зүйн баримт бичиг боловсруулах аргаар 150 минутын хугацаанд шалгах, 20 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр шалгалт өгнө. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшигчийн тухайд 5.1.1.2-т зааснаар сонгосон салбар эрх зүйтэй давхцахгүй байна.”

4/5.2.1.1 дэх дэд заалт:

“5.2.1.1.салбар эрх зүйн хууль хэрэглэх мэдлэг, чадварыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 30 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр тохиолдол шийдвэрлэнэ. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол нэр дэвшигч эдгээр салбар эрх зүйн аль чиглэлээр тохиолдол шийдвэрлэхийг өөрөө сонгоно.”

5/5.2.1.2 дахь дэд заалт:

“5.2.1.2.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх тухайлсан хуулийг хэрэглэх мэдлэг, чадварыг эрх зүйн баримт бичиг боловсруулах аргаар 150 минутын хугацаанд шалгах, 20 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр шалгалт

өгнө. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшигчийн тухайд 5.2.1.1-д зааснаар сонгосон салбар эрх зүйтэй давхцахгүй байна.”

6/5.2.1.3 дахь дэд заалт:

“5.2.1.3.шүүн таслах ажлын туршлагыг анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 20 хүртэл оноогоор үнэлэх. Эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол тухайн салбар эрх зүйн чиглэлээр шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийнэ. Эрүү, иргэний хэргийг хамт шийдвэрлэдэг давж заалдах шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшсэн бол нэр дэвшигч эдгээр салбар эрх зүйн аль чиглэлээр шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхийг сугалаагаар тодорхойлно.”

7/5.3.1.2 дахь дэд заалт:

“5.3.1.2.хууль тайлбарлах мэдлэг, чадварыг хууль тайлбарлан хэрэглэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 20 хүртэл оноогоор үнэлэх. Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр хууль тайлбарлахаа энэ журмын 5.3.1.3, 5.3.1.4-т сонгосон салбар эрх зүйтэй давхцуулахгүйгээр сонгоно.”

8/5.3.1.3 дахь дэд заалт:

“5.3.1.3.хууль хэрэглэх мэдлэг, чадварыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 20 хүртэл оноогоор үнэлэх. Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр эрх зүйн тохиолдол шийдвэрлэхээ сонгох бөгөөд энэ тухайгаа журмын 3.6-д заасан өргөдөлд тусгана.”

9/5.3.1.4 дэх дэд заалт:

“5.3.1.4. шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чадварыг анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд дүн шинжилгээ хийх аргаар 240 минутын хугацаанд шалгах, 20 хүртэл оноогоор үнэлэх. Нэр дэвшигч аль салбар эрх зүйн чиглэлээр дүн шинжилгээ хийхээ энэ журмын 5.3.1.2, 5.3.1.3-т сонгосон салбар эрх зүйтэй давхцуулахгүйгээр сонгоно.”

4.Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 57 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журам”-ын 5.1.1.4, 5.2.1.4, 5.3.1.5 дахь дэд заалтыг хассугай.

5.Энэ тогтоолыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

П.ЗОЛЗАЯА

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 2 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар
хот

ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх журам”-ыг шинэчлэн батлах тухай 383 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2026 оны 3 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авсан

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 2 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар А/34

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Онцгой албан татварын тухай хуулийн 4.2, 5.4, 6.4, 6.5 дахь заалтуудыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон тул “Тайлангийн маягт, нөхөх заавар батлах тухай” Татварын ерөнхий газрын даргын 2023 оны А/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Цахим тайлангийн системд өөрчлөлт оруулахыг Мэдээллийн технологийн төв /Б.Алтанхуяг/-д, хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Татвар төлөгчид үйлчлэх газар /Б.Буяннэмэх/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЦОГТНАРАН

